

10 БУРХАН: АНХААР

10.1 Миний бодол, арга барил та нарынхаас өөр

⁸“Учир нь Миний бодол санаанууд бол та нарын бодол санаа биш. Миний зам нь та нарын замаас өөр” гэж ЭЗЭН айлдаж байна. ⁹Тэнгэр нь газраас өндөр байдаг шиг, Миний зам та нарын замаас, Миний бодол та нарын бодлоос өндөр билээ.

¹⁰Бороо, цас тэнгэрээс бууж ирээд, газрыг услахгүйгээр буцдаггүй шиг, (харин газрыг ургуулж цэцэглүүлж, тариачинд үрийг, идэгчид талхыг нь хангадаг.) ¹¹Миний амнаас гарсан Миний үг хүслийг минь гүйцэтгэхгүйгээр, илгээсэн зорилгыг минь хэрэгжүүлэхгүйгээр Над уруу хоосон буцаж ирэхгүй.

¹²“Учир нь чи баяртайгаар гарч явж, амар тайвнаар хөтлүүлнэ. Уул толгод чиний өмнө баярлан уухайлж, талын бүх модод алга ташицгаана. ¹³Өргөст бутны оронд нарс, халгайн оронд мирт л ургана. Энэ бол ЭЗЭНд нэр,үл устах мөнхийн тэмдэг болно”. (Исаиа 55:8-13 АБ 2004)

[] Эдгээр ялгаа юу болохыг та мэдэх үү?

[] Биднийхээс ялгаатай зүйлсийг та жагсааж чадах уу?

10.2 Өнгөрсөнд бүү төвлөр

¹⁴Израилийн ариун Нэгэн, та нарын Аврагч ЭЗЭН ийнхүү айлдаж байна.
“Та нарын тусын тулд Би Вавилон уруу илгээн, тэднийг бүгдийг нь төдийгүй, усан онгоцон дотроо баясацгааж байсан халдеичуудыг оргодлууд мэт буулгана. ¹⁵Би бол ЭЗЭН, та нарын Ариун Нэгэн, Израилийн Бүтээгч, та нарын Хаан”.

¹⁶Тэнгис дундуур зам, хүчит их усан дундуур харгуй гаргагч ЭЗЭН ийнхүү айлдав. ¹⁷Тэр тэрэг ба морьд, их цэрэг ба хүчит эрийг гаргаж ирдэг. (Тэд хамтдаа тэнд хэвтэж, дахин босохгүй. Тэд зул мэт унтарч замхарна.) ¹⁸“Урьдын юмыг бүү дурсагтун. Өнгөрсөн юмыг бүү бодогтун. ¹⁹Үзэгтүн, Би

шинэ зүйл хийнэ. Одоо тэр нь бий болно. Та нар үүнийг мэдээгүй гэж үү? Би хээр талд зам тавьж, цөлд гол урсгана. (Исаиа 43:14-19 АБ 2004)

[] Та хуучин арга замаа хоослон шинийг хүлээн авах уу?

[] Хүмүүст “өнгөрсөндөө төвлөрөхөд” юу нөлөөлдөг вэ?

10.3 Хүний дүрмээр биш, харин Миний дүрмээр намайг шүтэгтүн

¹³Эзэн “Энэ ард түмэн амаараа ойртон, уруулаараа Намайг хүндлэвч, зүрхээрээ Надаас хол байна. Тэд Намайг эмээн хүндлэхэд захирагчдын тушаалаар суралцжээ. (Исаиа 29:13 АБ 2004)

[] Та зүрх сэтгэлээ хэрхэн ариусгадаг вэ?

10.4 Үхэл бол төгсгөл биш, шороо тоосноос үхсэн хүн амилах болно.

¹²ЭЗЭН, Та мөн бидний төлөө бүх үйлсийг минь бүтээсэн учраас Та бидний өлөө энхийг тогтооно. ¹³Аяа, бидний Бурхан ЭЗЭН, Танаас өөр эзэд биднийг захирсан боловч зөвхөн Танаар дамжуулан бид Таны нэрийг дурдах болно.

¹⁴Үхдэл нь амьдрахгүй, салан одсон сүнснүүд босохгүй. Тиймээс Та тэднийг шийтгэн устгаж, тэдний аливаа дурсамжийг арилгасан. ¹⁵ЭЗЭН минь, Та ндэстнийг олшруулж, үндэстнийг өсгөж, Та алдаршлаа. Газрын бүх хязгаарт Та хүрсэн.

¹⁶ЭЗЭН минь, тэд шаналахдаа Таныг эрсэн. Таны гэгсгээлт тэдний дээр байхад тэд зөвхөн шивнэн залбирч л чадна. ¹⁷Жирэмсэн эмэгтэй төрөхдөө овор, өвдөх шаналлаасаа болж орилдог шиг ЭЗЭН минь бид Таны өмнө ийм л байсан.

¹⁸Бид жирэмслэн, өвдсөн боловч салхи төрүүлж байгаа мэт байна. Бид дэлхийн төлөөх чөлөөлөлтийг гүйцээж чадсангүй. Ертөнцийн суугчид ч төрүүлсэнгүй.

¹⁹Таны үхэгсэд амилж, тэдний цогцос босно. Тоосонд хэвтэгчид ээ! Бос, баярлан хашхирагтун. Таны шүүдэр нь

гэрлүүдийн шүүдэр мэт билээ.
Газар нь сүнс сүгүүдийг гаргана. (Исаиа 26:12-19 АБ 2004)

- [] Хоосон эсвэл үүрд мөнх, аль нь таныг хөдөлгөдөг вэ?
[] Та сүнс сэтгэлийн авралд хэрхэн хүрч, мөн үхлээс хэрхэн дахин амилах вэ?

10.5 Алтан үхрийг санаарай

²⁴Би та нарыг мэдэх болсон тэр өдрөөс хойш та нар ЭЗЭНий эсрэг тэрсэлсээр ирсэн.²⁵ЭЗЭН та нарыг устгана хэмээн айлдсанаас болж би Түүний өмнө дөчин өдөр, дөчин шөнө түрүүлгээ харан хэвтсэн билээ.

²⁶Би ЭЗЭНд залбирсан бөгөөд “Эзэн БУРХАН, Та Өөрийнхөө сүр хүчээр зольсон, хүчирхэг мутраараа Египетээс гаргаж авсан Өөрийн ард түмэн Өөрийн өвийг битгий устгаач.

²⁷Та Өөрийн зарц Абрахам, Исаак, Иаков нарыг санаач. Энэ ард түмний зөрүүд зан, тэдний хорон муу байдал, тэдний нүглийг битгий хараач.²⁸Эс бөгөөс Таны биднийг гаргаж авсан тэр нутгийнхан “ЭЗЭН тэдэнд амласан газартаа тэднийг аваачих чадваргүй байсан учраас, мөн тэднийг үзэн ядсан учраас Тэр тэднийг цөлд алахаар авчирсан” гэж хэлэх болно.²⁹Тэд бол Таны агуу их хүчээрээ, сунгасан мутраараа гаргаж авчирсан Таны ард түмэн болох Таны өв билээ” гэсэн. (Дэд хууль 9:24-29 АБ 2004)

- [] Шүтээн шүтэхийг Бурхан яагаад үзэн яддагийг та мэдэх үү?
[] Шүтээн гэж юу болохыг та мэдэх үү?
[] Бардам зангийн шийтгэл нь дэлхий дээрх үхэл, мөнхийн хараал гэдгийг та мэдэх үү ?
[] Та хүмүүсийн өмнөөс Бурханы алдрын төлөө залбирдаг уу?

10.6 Гэмш, эргэ, амьдар

³²Учир нь Би үхэгсдийн хэнийх нь ч үхэлд баярладаггүй” гэж Эзэн БУРХАН тунхаглаж байна. “Тиймээс гэмшиж, амьдар”. (Езекиел 18:32 АБ 2004)

⁴¹Та нарыг ард түмнүүдийн дундаас гаргаж, тараагдсан газруудаас чинь цуглуулах цагт Би та нарыг тайвшруулах тааламжит үнэр мэт хүлээж авна. Үндэстнүүдийн нүдэн дээр та нарын дунд Би Өөрийгөө ариун гэдгээ нотолно. ⁴²Би та нарыг эцгүүдэд чинь өгөхөөр тангарагласан газар болох Израилийн нутаг уруу авчрах цагт та нар Намайг ЭЗЭН гэдгийг мэдэх болно.

⁴⁴Израилийн гэр ээ, Би та нартай муу явдлаар чинь, эсвэл завхарсан үйлсийн чинь дагуу бус, харин Өөрийн нэрийн төлөө та нартай харьцах үед та нар намайг ЭЗЭН гэдгийг мэдэх болно” гэж Эзэн БУРХАН тунхаглаж байна”
(Езекиел 20:41-42,44 АБ 2004)

¹¹Тэдэнд өгүүл. “Би Өөрийн амьд буйгаар тангараглая” гэж Эзэн БУРХАН тунхаглаж байна. “Би хорон муу хүний үхэлд огтхон ч баярлахгүй. Харин хорон муу хүн замаасаа эргэж, амьдрахад Би баярлах болно. Өөрийн муу замаасаа буцагтун, буцагтун! Тэгвэл та нар юунд үхэх вэ, Израилийн гэр ээ?”(Езекиел 33:11 АБ 2004)

²⁹Харин тэндээс чи өөрийн Бурхан ЭЗЭНийг эрэх болно. Хэрэв чи Түүнийг бүх зүрхээрээ, бүх сэтгэлээрээ эрвэл олно. ³⁰Энэ бүх зүйл чамд тулгарч, зовон зүдрэх үед, тэгээд хожмын өдөр чи өөрийн Бурхан ЭЗЭН уруу эргэж, Түүний дуу хоолойг сонсох болно. ³¹Чиний Бурхан ЭЗЭН өрөвч Бурхан мөн. Тэрээр чамайг орхих ч үгүй, чамайг устгах ч үгүй, чиний өвөг дээдэст тангарагласан гэрээгээ мартах ч үгүй. (Дэд хууль 4:29-31 ,44 АБ 2004)

Шунал бол шүтээн шүтэх явдал бөгөөд ялзрал , сүйрэлд хүргэж, амьдралыг дэмий хоосон болгодог.

[] Бурхан хүмүүсийг наманчилж, эргэж ирэхийг хүсдэг гэдгийг та мэдэх үү?

[] Хэрэв та зовлонгийн үед Түүний нүүр царайг эрэлхийлж, наманчилж дуулгавартай байх юм бол Бурхан таныг аварна гэдэгт чи итгэдэг үү?

[] Энэ амлалт биелэхийн төлөө та залбирдаг уу?

10.7 Абрахам Сара хоёрыг санагтун

¹“Үнэн зөвийг мөшгөн ЭЗЭНийг хайгчид аа. Намайг сонсогтун.

Та нарыг цавчиж авсан хад уруу, та нарыг малтаж гаргасан нүх уруу харагтун.

²Та нарыг шаналан байж төрүүлсэн Сараг болон та нарын эцэг Абрахамыг харагтун. Түүнийг ганцаараа байхад нь Би дуудаж, ерөөж, өсгөн үржүүлсэн юм. ³Үнэхээр ЭЗЭН Сионыг тайвшруулж, түүний бүх хоосон газрыг ч энэрнэ. Тэр зэлүүд талыг Еден шиг, цөлийг нь ЭЗЭНий цэцэрлэг мэт болгоно. Тэнд баяр баясгалан, зугаа цэнгэл, талархал, дуу хууртай байх болно. (Исаиа 51:1-3 АБ 2004)

[] Бурхан Абрамд юу хийснийг болон таныг ямар зүйлээс чөлөөлснийг санаж байна уу?

10.8 Бүх цус урсгалт хариу нэхэгдэнэ

⁵Тэгвэл Би та нарын цус, амин цусыг заавал нэхнэ. Амьтан бүрээс ч би түүнийг нэхнэ. Хүн хийгээд хүний ах дүү бүрээс ч нэхнэ. (Эхлэл 9:5 АБ 2004)

[] Энэ цус урсгалт нь илүү их цус шаардах болсныг та мэдэх үү?

10.9 Үндэстнүүд нь хувин доторх дусал мэт

¹⁵Үзэгтүн, үндэстнүүд бол хувин доторх дусал мэт хийгээд дэнсэн дээрх тоосны ширхэг мэт тооцогддог. Үзэгтүн, Тэр арлуудыг нарийн тоос мэт өргөнө.

¹⁶Ливан ч хүртэл шатаахад хангалтгүй, араатан амьтад нь ч шатаалт тахилд зориулахад хангалтгүй билээ.

¹⁷Бүх үндэстэн Түүний өмнө юу ч биш, тэд Түүнд утгагүй, хэрэггүй юм мэт үнэлэгддэг.

¹⁸Тэгвэл та нар Бурханыг хэнтэй адилтгах юм бэ? Та нар Түүнийг ямар дүртэй зүйрлэх вэ? ¹⁹Шүтээний хувьд гэвэл, түүнийг дархан хүн цутгаж, алтны дархан алтаар бүрж, мөнгөний дархан мөнгөн оосрыг нь хийдэг.

²⁰Иймэрхүү өргөлд хэтэрхий ядуу нь өмхөрдөггүй модыг

өөртөө сонгодог.
Үл хөдлөх шүтээнийг бүтээхийн тулд тэр уран дархныг хайдаг. (Исаиа 40:15-20 АБ 2004)

Итгэлгүй хичээл зүтгэл, сахилга батаар дүүрэн амьдрал нь хог хаягдал мэт

гэж үзэгдэнэ.

[] Та нар ертөнцөд байгаа зүйлс нь Бурханы хувьд хувин доторх дусал мэт харин авралын сайн мэдээг тунхаглах нь таны үүрэг даалгавар болохыг мэдэж байсан уу?

10.10 Дэлхий хуучирсан ч миний аврал үүрд мөнхөд үргэлжилнэ

⁴Миний ард түмэн, Надад анхаарал тавь. Миний үндэстэн, Над уруу чих тавигтун. Учир нь хууль Надаас гарна. Ард түмнүүдийн гэрэл болгон Өөрийн шударга ёсыг Би тогтооно. ⁵Миний үнэн зөв нь ойр байна. Миний аврал гарч ирж байна. Миний мутар ард түмнүүдийг шүүнэ. Эргийн нутгууд Намайг хүлээн, тэд Миний мутрыг горьдон хүлээнэ. ⁶Тэнгэр өөд харагтун. Дараа нь доош, газар уруу харагтун. Учир нь тэнгэр утаа мэт алга болж, газар хувцас мэт хуучирна. Оршин суугчид нь шумуул мэт үхэцгээнэ. Харин Миний аврал мөнхөд байж, Миний үнэн зөв мөхөхгүй. (Исаиа 51:4-6 АБ 2004)

[] Хүмүүс дэлхийтэй хамт хуучирахдаа өөрсдөдөө шийтгэл авчирж байгааг мэдэх үү?

[] Та Түүний зөвт байдал ба авралыг мэдэх үү?